

Оюутны эрдэм шинжилгээний бага хуралд зориулав.

Монгол улсын хөрөнгө оруулалтын үр ашигт авилгын үзүүлэх нөлөөлөл

Удирдагч багш:

Б.Бадамхүү /Эдийн засгийн ухааны магистр/

Боловсоруулсан:

Ж.Анударь /СЭЗДС Банк-3/

Г.Чанцал /СЭЗДС Санхүү-3/

Улаанбаатар хот , 2011 он

Агуулга

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ.....	2
1. ТАНИЛЦУУЛГА.....	3
2. ОНОЛЫН ХЭСЭГ.....	5
2.1 Хөрөнгө оруулалт, түүний өгөөжийг тооцох нь.....	5
2.2 Авилга, түүний эдийн засаг дахь нөлөөлөл	6
3. Судалгааны хэсэг	
3.1 Дэвшүүлсэн таамаглал	7
3.2 Монгол улсын хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх нь.....	7
3.3 Загварын тайлбар.....	9
ДҮГНЭЛТ.....	10
САНАЛ ЗӨВЛӨМЖ	10
ЭХ СУРВАЛЖ.....	11
ХАВСРАЛТ	12

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар Монгол улсын капиталын өгөөж буюу хөрөнгө оруулалтын үр ашигт өнөөгийн нийгмийн томоохон тулгамдсан асуудлуудын нэг авлига хээл, хахууль сөрөг байдлаар нөлөөлж байгаа эсэхийг тодруулах юм. Шинжилгээг хийхдээ хамгийн бага квадратын аргаар шугаман регрессийн загвараар үнэлсэн бөгөөд эхний шинжилгээ хийхэд үүссэн автокорреляцийг засварласан бөгөөд шугаман бус загварыг шугамчилсан болно. Судалгааг хийхэд ашигласан тоон мэдээллүүдийг Дэлхийн Банк болон Трансперинси Интернэшнлийн тайлангаас авсан.

2007 онд Mushfig болон Swaleheen нарын хийсэн “Авилга ба хөрөнгө оруулалтын сонголт” хэмээх олон улсын өгөгдөл ашиглан гаргаж ирсэн загварыг Монгол улсын хувьд ашиглахын тулд зарим өөрчлөлтийг хийсэн бөгөөд ингэснээр загварын итгэлтэй байдал сайжирсан.

Түлхүүр үгс: авлига, хөрөнгө оруулалтын өгөөж, ДНБ

1. Танилцуулга

Судлах болсон шалтгаан: Улс орны эдийн засгийн өсөлтөд тухайн улсын эдийн засгийн тогтолцоо, улс төр, нийгэм соёлын маш олон хүчин зүйлүүд нөлөөлдөг ч тэр дундаас олон нийтийн үзэл бодол, ашиг сонирхолд маш хүчтэйгээр нөлөөлж эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байдаг зүйл бол яахын аргагүй авлига, хээл хахууль билээ.

Тэр дундаа манай улс шиг хөгжиж буй, эдийн засгийн харилцаанд төр ихээхэн чухал байр суурийг эзэлдэг улсын хувьд төрийн үйл ажилгааг хэрэгжүүлэгчид хэр үнэн зөв, шударга ажиллахаас эдийн засгийн хөгжил ихээхэн хамаарч байна. Авлигатай холбоотой хийгдсэн ихэнх судалгаанаас харахад ихэвчлэн жирийн ард иргэдийн өдөр тутмын амьдралд тохиолдож буй авилгын тохиолдлуудад хандсан судалгаа байдаг бөгөөд дээд түвшинд улсын чухал асуудлуудыг эрхэлж буй албан хаагчдад хандсан судалгаа тун бага байдаг. Гэвч бодит байдал дээр ард иргэдийн амьдралд маш ихээр нөлөөлж чадах шийдвэрүүдийг гаргаж буй хүмүүсийн авч буй авилгын хэмжээ нь маш өндөр бөгөөд нийгэмд үзүүлэх хор нөлөө нь их байдаг.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн томоохон ордууд ашиглалтанд орсонтой холбоотойгоор манай улс эдийн засгийн хувьд өсөн дэвжих томоохон боломж бий болж байна. Энэхүү боломжийг үр ашигтай ашиглаж чадах эсэх нь мөн л төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэгч албан тушаалтнуудын үйл ажиллагаанаас шууд хамаарсан хэвээр байгаа билээ. Тиймээс манай улсад орж ирж буй энэхүү ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтын үр ашигт авлига хэр хэмжээтэйгээр сөргөөр нөлөөлөлж байна вэ гэдэг нь судлаач оюутан бидний сонирхолыг ихээр татлаа.

Судалгааны зорилго: Бид дээрх асуултанд хариулт олох үүднээс доорх зорилгыг дэвшүүлж байна.

- Монгол улсын хөрөнгө оруулалтын үр ашигт авлига ямар нөлөө үзүүлж байгааг тодохойлох

Судалгааны ач холбогдол: Энэхүү судалгааг хийснээр бодитоор бидний авч чадах байсан хөрөнгө оруулалтын өгөөжийг авилга хэрхэн бууруулдаг, түүний эдийн засагт үзүүлж буй дарамтыг тодорхой итгэх түвшинд тодорхойлно. Ингэснээр авлигатай тэмцэх эрх бүхий байгууллагууд авилгатай тэмцэх аргаа илүү боловсронгуй болгох боломжтой болно.

Судлагдсан байдал: 1995 онд судлаач Мауго “Авилга ба өсөлт” судалгаандаа авлилга ба хээл хахууль нь хөрөнгө оруулалтын түвшинг бууруулдаг бөгөөд эдийн засгийг хаалттай, улс төрийн байдал тогтворгүй болгоход хүргэдэг талаар хэд хэдэн жишээн дээр нотолсон. Меон болон Sekkat нар 2005 онд хийсэн судалгаандаа хэрвээ тухайн улсын засаглалын орчин муу бол авилга нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлдөг хэмээн нотолсон байдаг.

2007 онд Mushfigболон Swaleheenнарын хийсэн “Авилга ба хөрөнгө оруулалтын сонголт” хэмээх судалгаанд улс орны орлогын түвшинээс хамааран авилга хөрөнгө оруулалтын үр ашигт хэрхэн нөлөөлдөг талаар 140 гаран орны өгөгдөл ашиглан ерөнхий хамаарлыг нь гаргаж ирсэн.

Судалгааны арга аргачлал:2004-2010 оны 7 жилийн макро түвшний үзүүлэлтүүд болон AR/1/ буюу 1 хугацааны өмнөх хөрөнгө оруулалтын өгөөжөөс хамааруулан шугаман регрессийг хамгийн бага квадратын аргаар үнэлсэн болно.

2. Онолын хэсэг

2.1 Хөрөнгө оруулалт, түүний өгөөжийг тооцох нь

Улсын нийт хөрөнгө оруулалтын талаарх ойлголт

Хөрөнгө оруулалт гэж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хуримтлалыг шинээр буй болгох, түүний техникийн зэвсэглэмжийг дээшлүүлэн өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант жилд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардлыг хэлнэ. Монгол улсын хувьд нийт хөрөнгө оруулалтыг дараах байдлаар ангилдаг:

Хөрөнгө оруулсан технологийн бүтцээр	<ul style="list-style-type: none">• Барилга угсралт• Тоног төхөөрөмж• Бусад
Санхүүжилтийн эх үүсвэрээр	<ul style="list-style-type: none">• Дотоод /Улсын төсөв, Бусад/• Гадаад /Гадаадын шууд хөрөнгө оруулалт Бусад /

Нийт хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцох:

Нийт улсын хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцох нь бизнесийн салбар дахь компаний хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцох аргаас өөр боловч үндсэн санаа нь ижил байдаг. Бидний энэхүү судалгааны ажилд хөрөнгө оруулалтын өгөөж гэдэг нь нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нэг хувиар өсөхөд дотоодын нийт бүтээгдэхүүн нэг хувиар өснө гэсэн ойлголт дээр тулгуурсан болно.

Бид судалгааны ажилдаа хөрөнгө оруулалтын өгөөжийг Монгол хэлээр утгачлан орчуулбал “Нэмэгдүүлсэн Хөрөнгийн Гарцын Харьцаа” буюу “Incremental Capital Output Ratio”-н урвуу утгаар тооцсон. Энэ харьцаа нь бусад хөрөнгө оруулалтын өгөөж тооцох “Хөрөнгийн Дундаж Гарцын Харьцаа” (тухайн хугацааны хөрөнгө оруулалт/ тухайн хугацааны ДНБ) тооцох аргаас хөрөнгө оруулалтын өгөөжийг өнгөрсөн болон одоогийн үзүүлэлтүүдийг хамтад нь ашигладгаараа манай судалгааны онцлогт илүү тохирч байгаа.

“Нэмэгдүүлсэн Хөрөнгийн Гарцын Харьцаа”-г тооцох нь:

$$НХГХ_t = \frac{\text{Хөрөнгө оруулалт}_t - \text{Хөрөнгө оруулалт}_{t-1}}{\text{ДНБ}_t - \text{ДНБ}_{t-1}} \quad \text{Энд: } t - \text{тухайн жил}$$

2.2Авилга, түүний эдийн засаг дахь нөлөөлөл

Авилгын талаарх үндсэн ойлголт

Авилга гэдэг нь Монгол улсын хуульд заасанчлан төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж буй төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчидэрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлдэг.

Монгол улсын хувьд 2006 оноос хойш авлигатай эрчимтэйгээр тэмцэж эхэлсэн бөгөөд 2006 оны 07 сарын 06 өдөр Авилгын эсрэг хуулийг баталж албан ёсоор 2006 оны 11 сарын 1-ны өдөр Авилгатай тэмцэх газрыг байгуулсан.АНУ-ынОлонУлсынХөгжлийнАгентлаг (ОУХА)-ийн хийсэн судалгаанаас харахад манайд “жигжсэжиг” буюузахиргаанытүвшинд ч, “иххэмжээний” буюуэлиттүвшинд ч авилгалынболомжөндөр байдаг бөгөөд их хэмжээний авилгын үр нөлөө нь эдийн засгийн бодит өгөөжийг маш ихээр бууруулдаг байна.

Авилгын эдийн засаг дахь нөлөөлөл

Дэлхийн маш олон эрдэмтдийн эмпирик судалгааны үр дүнгээс харахад авилгал нь тухайн улсын үндсэн хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулдаг бөгөөд улс төрийн тогтворгүй байдлыг нэмэгдүүлдэг хэмээн нотолсон байдаг.

Мөн түүнчлэн манай улс шиг орлогын түвшин доогуур, хөгжиж буй орны хувьд авилгын нөлөөлөл нь эдийн засаг, улс төрийн өндөр хөгжилтэй улс орнуудтай харьцуулахад илүү өндөр бөгөөд авилгын бууралт нь эдийн засагт эерэг нөлөөллийг бий болгодог байна.

Авилга нь манай улсын хувьд төрийн хэрэгжүүлэгч агентлагуудаар дамжуулан орж ирж буй гадны болон улсын төсөвөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалтуудын хэргэжилтэд ч ихээхэн саад учруулдаг бөгөөд ашиг сонирхолын зөрчлөөс үүдэн хөрөнгө оруулалтын бодит өгөөжийг бууруулж байна.

3.Судалгааны хэсэг

3.1Дэвшүүлсэн таамаглал

Улс оронд авилга бага байх нь хөрөнгө оруулалтын өгөөжид эерэгээр нөлөөлнө. Өөрөөр хэлбэл авилга нь тухайн улсын хөрөнгө оруулалтын үндсэн өгөөжийн үр ашгийг бууруулж байдаг.

3.2Монгол улсын хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх нь

Судалгааг хийхдээ монгол улсын хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцох макро түвшний 2004-2010 оны долоон жилийн хоорондох үзүүлэлтүүдийг сонгон авсан бөгөөд хамааран хувьсагчидад тооцсон. Тэдгээрт: нийт хүн амын өсөлтийн хувь, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний ДНБ-д эзлэх хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг ДНБ-д харьцуулсан харьцаа, нийт импортын хэмжээг ДНБ-д харьцуулсан харьцаа, нэгхүндноогдохДНБ болно.

Хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоход ашигласан өгөгдөлүүдийг Трансперинси Интернэшнл олон улсын байгууллагаас жил болгон гаргадаг Авлигын төсөөллийн индекс (АТИ) болон Дэлхийн банкнаас гаргадаг Дэлхийн хөгжлийн илтгэлцүүрээс авсан болно.

Өгөгдлийн шинжилгээ:

Дээр дурдсан макро орчны хүчин зүйлсийн 7 жилийн панел өгөгдлийг олон хүчин зүйлийн регрессээр үнэлэхдээ хэд хэдэн таамаглал дэвшүүлсэн бөгөөд тэдгээрийг үнэлгээний өмнөх тестүүдээр шалгаж үзэхэд зарим хүчин зүйлсийн хоорондын хамаарал нь 0,6-с дээш буюу хүчтэй шугаман хамааралтай байсан тул

- Хүн амын өсөлтийн хувь
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний ДНБ-д эзлэх хувь гэсэн хоёр үзүүлэлтийг шинжилгээнээс хассан болно.

Регрессийн шинжилгээ хийх явцад тайлбарлагч хүчин зүйлс нь хоорондоо хүчтэй шугаман хамааралгүй(корреляцийн коэффициентууд нь 0.60-с бага),тайлбарлагч болон тайлбарлагдагч хувьсагчид хоорондоо шугаман бус хамааралтай бөгөөд хэвийн тархалттай болох нь тогтоогдсон. Мультиколлинеарын асуудлыг хэвийн тархалтын хэтилт болон (skewness), овойлт (kurtosis), Жаркю-Берра тестээр шалгасан болно.

Регрессийн шинжилгээг доорх тэгшитгэлээр илэрхийлсэн:

$$Y_{it} = \alpha X_{it} + \beta \text{CPI}_{it} + \varepsilon$$

X буюу үл хамаарах хувьсагчдад доорх хүчин зүйлсийг оруулан тооцов:

1. Industry –аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг ДНБ-д харьцуулсан харьцаа
2. Import-нийт импортын хэмжээг ДНБ-д харьцуулсан харьцаа
3. perGDP – нэгхүндноогдох ДНБ
4. CPI 1-Авлигын төсөөллийн индексийн квадрат зэрэг (10-авилгал байхгүй, 1-авилгалын түвшин хамгийн өндөр)
5. ε -алдааны үлдэгдэл

Шинжилгээний үр дүн:

$$Y = 0.1306180582 * \text{CPI1} + 8.545159473 * \text{INDUSTRY} - 1.132641605 * \text{LOGIMPORT} - 0.00280856353 * \text{perGDP} + [\text{AR}(1) = -0.6687759911]$$

Загварын үнэлгээний үнэлгээ			
R-квадрат	0.999933	Жаркю-Бера	0,544267
Засварлагдсан R-квадрат	0.999665	Акайка шинжүүр	-5.983819
Дунджийн стандарт алдаа	0.012929	Шварцын шинжүүр	-6.157352
Тайлбарлагч хүчин зүйлсийн үнэлгээ			
	Коэффициент	t-статистик	Итгэх магадлал 0,05
CPI1	0.130618	23.65502	0.0269
INDUSTRY	8.545159	36.15612	0.0176
LOGIMPORT	-1.132642	-9.101443	0.0697
PPP	-0.002809	-118.7073	0.0054
AR(1)	-0.668776	-76.46401	0.0083

3.3 Загварын тайлбар

Дээрх томъёоноос харахад бидний дэвшүүлсэн эхний таамаглал батлагдаж авилгын төсөөллийн индекс нэг нэгжээр нэмэгдэхэд хөрөнгө оруулалтын өгөөж

$0.1306*(CPI_i^2 - CPI_{i-1}^2)$ гэсэн нэгжээр нэмэгдэнэ.

Монгол улсын АТИ-н бодит түвшин дэх хөрөнгө оруулалтын өгөөж болон огт авилгалгүй нийгэм буюу АТИ=10 байх үеийн ХОӨ-г харьцуулан харуулья.


Хүснэгт: Хөрөнгө оруулалтын өгөөж(бодит АТИ, боломжит АТИ)

Он	АТИ	ХОӨ(бодит)	АТИ	ХОӨ(боломжит)
2004	3	3.725468	10	14.25749128
2005	3	1.630778	10	11.92701971
2006	2.8	3.212056	10	13.55322014
2007	3	1.995234	10	12.14495808
2008	3	1.712511	10	11.99545266
2009	2.7	1.188812	10	12.33390509
2010	2.7	1.510718	10	12.69670884

Эх сурвалж: Трансперинси Интернэшнл АТИ 2004 – 2010

Дээрх тоон үзүүлэлтийг графикаар харуулвал:

График: Хөрөнгө оруулалтын өгөөж(бодит АТИ, боломжит АТИ)



Дээрхээс харахад эдгээр жилүүдийн хугацаанд нийт 88,91 нэгж хөрөнгө оруулалтын өгөөж авах боломжтой байсан ч гэсэн манай улсад авилга, хээл хахууль өндөр байгаагаас шалтгаалаад дөнгөж нийт хөрөнгө оруулалтын өгөөжийн нь 14,98 нэгжийг авч чадсан буюу 73,93 нэгж өгөөжөө алдсан байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны зорилго нь авлига хээл хахууль нь хөрөнгө оруулалтын өгөөжид сөргөөр нөлөө үзүүлдэг эсэхийг тогтоох юм.

Хүмүүс ихэвчлэн авлигын шууд илрэх сөрөг нөлөөг олж хардагч түүний дам нөлөөлөл нь макро түвшний үзүүлэлтүүдэд нөлөөлж, иргэн бүрийн амьдралд өөрийн хар сүүдрээ тусгадгыг тэр болгон олж хардаггүй. Түүнчилэн дээрх материалуудаас харахад авлигын шууд бус нөлөөлөл нь монголын эдийн засгын үр ашигтай байдлыг бууруулж, цаашлаад нийгмийг доройтуулахад хүрэлхүйц хэмжээнд очжээ. Үүний нэг жишээ нь нийт хөрөнгө оруулалтын үр ашигт байдал буюу авах боломжит өгөөжийг бууруулснаараа нэг хүнд ноогдох ДНБ-н ашигт байдлыг давхар багасгаж байна. Тоон үзүүлэлтүүдээс харахад хамаарагч хүчин зүйлсийн өсөлтийн хувь жил бүр өндөр байгаа ч бодит өгөөжийн түвшин хангалттай хэмжээнд хүрэхгүй байна. Ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтаас монголчуудад үлдэх өгөөж нь маш бага байгаа нь энэ хүнд суртал, хээл хахуулиас улбаатай. Дээрх мэдээллүүдэд тулгуурлан дүгнэлт хийвэл эрх баригчид бодлогын арга хэмжээнд зохицуулалт хийснээр Монгол улсад орж ирж буй ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг үр ашигтайгаар зарцуулж, улс эх орныхоо хөгжилд томоохон түлхэц болно боломжтой юм.

Энэхүү судалгааг зөвхөн макро түвшний үзүүлэлтүүдэд тулгуурлан хийсэн бөгөөд загварыг тухайн орны үйл ажиллагаагаа явуулдаг компаниудын санхүүгийн мэдээллийг ашиглан сайжруулах боломжтой.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Дээрх судалгааны үр дүнгээс харахад хөрөнгө оруулалтын өгөөж 80 орчим буурахад жирийн ард иргэдийн өдөр тутмын харилцаанд үүсч буй авилгын тохиолдолоос илүүтэйгээр төрийн хэргжүүлэгч агентлагууд болон шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнуудын хооронд үүсч буй авилгын тохиолдол илүү их нөлөөтэй. Тийм учраас дараах үйл ажиллагааг санал болгож байна:

- Авлигатай тэмцэх газар төрийн дээгүүр алба хаагч эрх мэдэлтнүүдийн авилга авах болон өгөх үйл ажиллагааг зогсоход одоо байгаагаасаа илүүтэйгээр хяналт тавих
- Ард иргэдэд өөрсдийн сонгосон улсын их хурал болон засгийн газрын үйл ажиллагааг хянах нь улс төрийн эрх ашгаас гадна эдийн засгийн эрх ашгаа хамгаалахад нь хэр ач холбогдолтой талаар ойлголт өгөх ухуулга, сурталчилгаа сургалт зохион байгуулах.

ЭХ СУРВАЛЖ

1. Mushfiq us Swaleheen(2007). Corruption and Investment Choices.KYKLOS, Vol. 60 – 2007 – No. 4, 601–616
2. Mauro, P. (1995). Corruption and growth, Quarterly Journal of Economics. 110: 681–712.
3. Mo, P.H. (2001). Corruption and economic growth, Journal of Comparative Economics. 29: 66–79.
4. Transparency International.(2004-2010). Corruption Perceptions Index, available at <http://www.transparency.org/surveys/index.html#cp>.
5. Asian foundation, Mongolia Corruption Benchmarking Survey X, IX
6. World Bank (2004 - 2010). World Development Indicators.available at <http://www.devdata.worldbank.org>.
7. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл: 2004-2010
8. Наранчимэг Ч. Д.Ганзориг (2010). Бизнесийн статистик, Эконометрикийн үндэс Улаанбаатар, Монгол улс
9. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны товч танилцуулга.(2009), Улаанбаатар, Монгол улс

Хавсралт 1: Хамааран хувьсагчид

	АТИ	ХАА, ДНБ- н харьцаа	Аж үйлдвэр, ДНБ-н харьцаа	Импорт, ДНБ- н харьцаа	Нэг хүнд ноогдох ДНБ (\$)	Хүн амын өсөлт
2003	3	0.22607468	0.31979755	0.705415433	688	0.01171498
2004	3	0.22058959	0.362077182	0.636120761	801	0.012990421
2005	2.8	0.19617598	0.430214329	0.53486718	998	0.01434464
2006	3	0.20458096	0.418918562	0.58265978	1054	0.015499906
2007	3	0.21412780	0.343795031	0.671809775	1111	0.016238126
2008	2.7	0.19626703	0.330215346	0.575357578	1079	0.016428668
2009	2.7	0.18094303	0.368382184	0.663775079	1133	0.016220091
2010	3	0.22607468	0.31979755	0.705415433	688	0.01171498

Хавсралт 2: Загварын үнэлгээ

Dependent Variable: K
 Method: Least Squares
 Date: 11/26/11 Time: 09:37
 Sample(adjusted): 2005 2010
 Included observations: 6 after adjusting endpoints
 Convergence achieved after 6 iterations

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
CPI1	0.130618	0.005522	23.65502	0.0269
INDUSTRY	8.545159	0.236341	36.15612	0.0176
LOGIMPORT	-1.132642	0.124446	-9.101443	0.0697
PPP	-0.002809	2.37E-05	-118.7073	0.0054
AR(1)	-0.668776	0.008746	-76.46401	0.0083

R-squared	0.999933	Mean dependent var	1.875018
Adjusted R-squared	0.999665	S.D. dependent var	0.705943
S.E. of regression	0.012929	Akaike info criterion	-5.983819
Sum squared resid	0.000167	Schwarz criterion	-6.157352
Log likelihood	22.95146	Durbin-Watson stat	1.156607

Inverted AR Roots	-0.67
-------------------	-------

Хавсралт 3: Бодит, үнэлэгдсэн утгууд болон үлдэгдэлийн график

